

# ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ТАЛБАЙН УРД ХЭСГИЙН ТОХИЖИЛТЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

## НЭГ. ЕРӨНХИЙ АГУУЛГА

### 1. ЗОРИЛГО

Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайн урд хэсгийн тохижилтыг шинэчлэх шинэ санаа, шилдэг шийдлийг мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоотой тодорхойлох.

### 2. УРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- Зураг төслийн мэргэжлийн байгууллага;
- Хувь хүн, мэргэжлийн уран бүтээлчид, мэргэжлийн сургуулийн оюутан залуус зураг төслийн мэргэжлийн байгууллагатай хамтран оролцоно.

### 3. ХУГАЦАА

Уралдааныг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүртэл явуулна.

### 4. АЖЛЫН БҮРДЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Зураглалын иж бүрдэл А3 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /\*.dwg, \*.pdf, \*.jpg, \*.max/
- Тайлбар бичиг, танилцуулга А4 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /\*.doc, \*.pdf, \*.ppt/
- Үзэсгэлэнгийн самбар 90x90 см хэмжээтэй.

### 5. ЗОХИОГЧИЙН ЭРХ

- Шилдгээр шалгарсан бүтээлийн зохиогчийн эрх нь уралдаан зарласан захиалагч байгууллагын талд үлдэх ба цаашид ашиглах, хөгжүүлэх онцгой эрх захиалагч байгууллагад хадгалагдана.
- Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж олгохгүй бөгөөд захиалагч байгууллагын архивд үлдэнэ.
- Шилдэг санааг боловсруулсан оролцогч тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах ажилд давуу эрхтэй оролцоно.

### 6. МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ

Уралдаанд оролцох материалыг 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10:00 - 16:00 цагийн хооронд дараах хаягаар хүлээн авна.

*Хот байгуулалт, хөгжлийн газар /Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Нийслэлийн Засаг захиргааны II байр, Хангарди ордон, 11 давхрын хурлын танхим/*

### 7. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Нийслэлийн Засаг даргын тамгын газар;
- Хот байгуулалт, хөгжлийн газар;

## ХОЁР. ШАЛГАРУУЛАЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

### 8. ШАЛГАРУУЛАЛТ

Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон уралдааныг дүгнэх үүрэг бүхий комиссын гишүүд уралдаанд ирүүлсэн бүтээлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1.	Бүтээлийн үзэл санаа, шинэлэг байдал	20
2.	Үндэсний онцлог, түүх, соёлын хэв шинжийг тусгасан байдал	20
3.	Байгаль орчинд ээлтэй, орчин үеийн технологийн шийдэл тусгасан байдал	20
4.	Ажлын гүйцэтгэл, иж бүрдлийн шаардлагыг хангасан байдал	20
5.	Олон нийтийн санал	20
6.	Нийт	100

### 9. ШАГНАЛЫН САН, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Нийт шагналын сан: 30.000.000 /гучин сая/ төгрөг

- Шилдэг санаа: 20.000.000 /хорин сая/ төгрөг;
- 2 шагналт байрыг шалгаруулна /тус бүр 5 сая төгрөг/.

## ГУРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Оролцогчид дараах асуудлын хүрээнд гомдол гаргаж болох бөгөөд бусад асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч хэлэлцэхгүй.

- Зохиогчийн эрх зөрчигдсөн асуудлаар */Хувь хүн болон байгууллагын бүтээлийг хуулбарлаж оролцсон/;*
- Уралдааныг дүгнэх комиссын бүрэлдэхүүнд багтсан гишүүнтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдсэн үед;

Гомдлыг шилдэг бүтээлийг шалгаруулж зарласнаас хойш 1 хоногийн дотор бичгээр үйлдэж зохион байгуулагчид хүргүүлнэ. Хугацаа хожимдсон болон гомдол гаргасан үндэслэлээ баталгаажуулж хавсаргаагүй гомдлыг хүлээж авахгүй.

### Дэлгэрэнгүй мэдээллийг:

Хот байгуулалт, хөгжлийн газар /Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Хангарди ордон, 13 давхар, 1302 тоот/ 11-321943 утсаар болон [www.uda.ub.gov.mn](http://www.uda.ub.gov.mn) сайтаас;